

Хэлний хэрэглээний алдаа судлал: хүнд суурилсан хандлага

Нямжавын Нансалмаа*

Монгол Улс, МУИС-ийн ШУС-ийн Европ судлалын тэнхим

Received: Oct 23, 2023

Revised: Nov 22, 2023

Accepted: Dec 15, 2023

Хураангуй: Энэхүү өгүүлэлд хэлний салбарын судлаачдын эрдэм шинжилгээний өгүүлийг баримт болгон авч, хэм хэмжээнээс гажсан хэрэглээнд дүн шинжилгээ хийн, алдааны хэв шинж, шалтгааныг тодорхойлохыг зорив. Хэлний хэм хэмжээг зөвхөн хэлний тэмдгийн тогтолцоонд хамааруулах нь хангалтгүй, харин хэлийг хэрэглэгч хүнд хамааруулж үзэх нь зүйтэй юм. Эрдэм шинжилгээний салбарт ажиллагсад бүтээлдээ хос (олон) хэл хэрэглэдэг бодит байдлаас үүдэн хэл холилдох үзэгдэл болж, монгол хэлэнд гадаад, тухайлбал, англи хэл, монгол хэлний тогтолцооны бүх түвшинд мэдэгдэхүйц нөлөөлөх болжээ гэж дүгнэв.

Түлхүүр үг: эрдэм шинжилгээний бүтээлийн хэл, хэлний хэм хэмжээ, алдааны хэв шинж, хэл холилдох, гадаад хэлний нөлөө

The Study of Language Use Errors: The Person-Based Approach

NANSALMAA Nyamjav

Department of European Studies, the School of Arts and Sciences,
National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

Abstract: In this article, the academic articles of researchers in the linguistic field are considered as study materials in terms of linguistic norm and error analysis. Linguistic norms shouldn't solely be based on the semiotics, but also look at the language users, with a person-based approach. As a result of the study, we have found a serious case of language transfer in Mongolian research papers, through an excessive and inappropriate use of foreign languages, particularly English.

Keywords: the language in research papers, linguistic norm, typology of error, code-mixing, and language transfer

* © Н.Нансалмаа
Email: nansalmaa@mail.ru

1. Удиртгал

Хэл шинжлэлийн салбарын ахисан түвшний оюутны судалгааны ажил удирдах, хянах, шүүмж бичих; сурах бичиг, судалгааны ном, бүтээл, нэг сэдэвт зохиол, эрдэм шинжилгээний сэтгүүлд ирүүлсэн өгүүлэл хянан магадлах ажил хийж ирсэн олон жилийн туршлагаас үзвэл, хэлний хамт олон заавал дагах үүрэгтэй утга зохиолын хэм хэмжээт хэлний нэгэн төрөл эрдэм шинжилгээний хэл найруулгад гарч буй өөрчлөлтийг анхаарах цаг болсныг сануулах болжээ.

Хэл яриа алдаатай бол буруу гэдэг. Алдаа бол дүрэм буюу хэм хэмжээ зөрчих үзэгдэл. Хэлний хэрэглээний алдаа судлал өнгөрсөн зууны эхээр хэлний дүрэм зөрчих үзэгдэл хэмээх тайлбартай эхэлж, цаашид зүй тогтолт үзэгдэл хэмээн үзэх болж, улмаар зөвхөн цэвэр хэл шинжлэл төдийгүй зэрэгцүүлсэн хэл шинжлэл, сэтгэц хэл шинжлэл, хэл соёл судлал болон хос хэлний боловсрол талаас хэлэхүйн үйл дэх хэл яриа үүсэх, хүлээж авахад гарах алдаа, тэдгээрийн шалтгааныг тогтоох зорилготой болжээ. Энэ талаар орос, англи хэлээр туурвисан судалгааны бүтээл арвин байна (Верещагин, 1968; Виноградов, 2003; Виноградов, 1983, 1990; Цейтлин, 1982; Залевская, 2008, 2013; Дебренин, 2006; Жлуктенко, 1974; Aitchison, 2003; Larsen-Freeman & Long, 1993; Selinker, 1997; Sanz, 2005; Goldrick, 2006; Tega, 2006). Эдгээр бүтээл гол төлөв өөрийнх нь хэлийг судалж байгаа гадаад хүн, эсвэл гадаад хэл судалж байгаа өөрийнх нь хэлтэн, эсвэл, хэлд орж байгаа өөрийн хэлтэн хүүхдийн хэлэхүйн алдаа судалсан байх бөгөөд өөрийн хэлтэн насанд хүрсэн хүн өөрийн хэл хэрэглэхэд гаргаж байгаа алдааг судалсан нь ховор байна.

Өнөөгийн шатанд алдааны сан бүрдүүлж шалтгааныг тодруулан ангилахад бүтэц хэл шинжлэл, сэтгэл судлал, сэтгэц хэл шинжлэл, хэл заах арга зүйн талаас судлах гэлгүй, хүн хэл эзэмших үйлийг нейро хэл шинжлэл талаас судалж, хэлний хэрэглээнд гарах хэм хэмжээ зөрчсөн үзэгдэл буюу алдааг хэлээр дамжуулж мэдээлэл хүлээж авах, таних, боловсруулах, хадгалах, хэрэглэх замаар “өөрийн тархины хэлний тогтолцоо” бүтээх, энэхүү бүтээсэн тогтолцоог хэлэхүйд ашиглах үйлийг судлах хэрэгтэй байна. Шинжлэх ухааны орчин цагийн танихуйн нейросайнс гэх салбар дундын шинжлэх ухааны нэг суурь ухаан болсон хүний хэлний тухай шинжлэх ухаан “**хүн танин мэдэх, мэдээлэл боловсруулах тогтолцоо**”, “**хэл танин мэдэх тогтолцоо, танин мэдэх хэрэглүүр**” гэх хоёр суурь зарчимтай хэмээн тодорхойлж болно. Ямар хэл ашиглаж ямар төрлийн мэдлэг хуримтлуулж байгаа нь түүний тархин дахь хэл болон мэдлэгийн тогтолцоог бүтээнэ. Хэл шинжлэлийн мэдлэг болон энэ мэдлэгийг тайлбарлах мета хэл бүрэлдэнэ. Нөгөө талаас, мэдээлэл боловсруулдаг тогтолцоо гэж буй хүн өөрөө өөрийгөө бүтээнэ. Ямар хүн болж өөрийгөө бүтээснийг түүний бүтээсэн бичвэрээр дамжуулан харах боломжтой болно.

Танин мэдэх, харилцах үйлийн явцад хувь хүний ухамсар болон сэтгэхүй (танин мэдэх, ойлгох, тайлбарлах) бүрэлдэн тогтох зүй тогтол ямар болох,

энэхүү зүй тогтлыг танин мэдэх, сурах үйлд ашиглахыг танихуй гэнэ. Танихуйн хандлагаар дараах зарчим баримтална:

- Хэлний үзэгдлийг сэтгэх, танин мэдэх чадвартай хүнтэй нь холбож тайлбарлах (хэлэнд шингэсэн мэдлэгийг хүлээж авах, сэтгэх, бодит ертөнцийг өөрийн танихуйн туршлагаар шүүж ухагдахуун, цогц ойлголт, төсөөлөл, дүр хэлбэрээр ойлгох, загварчлах);
- Хэл бүр бодит ертөнцийг тухайн хэлээр хэлэлцэгчдийн хамтын ухамсар, ухагдахууны тогтолцоогоор дамжуулан айчилж, бүтэцжүүлж, тайлбарладаг. Өөрөөр хэлбэл, хэл бүр ийм тогтолцоотой дүйнэ;
- Хэлний хэлбэрийг сэтгэлгээний тусгал болон мэдлэг дамжуулах бүтэц гэж үздэг танихуйн туршлагатай хамааруулж ойлгох;
- Харилцааны тодорхой нөхцөлд үндэсний соёлын жишиг болдог хэлний хамт олны төсөөлөл, хандлагыг танин мэдэх сэтгэлгээний үндсэн судлахуун хэмээн хүлээн зөвшөөрөх зэрэг.

Хэл шинжлэлийн аливаа судалгаанд өгүүлэгч / бичигчийн хэл яриа бүтээх үйл болон уг үйлийн үр дүн болсон өгүүлэмж эсвэл бичвэрийг хэл хэрэглэгч өөрийн тархинд бүтээсэн сэтгэлгээний хэлний илрэл гэж үзэн, тархин дахь түүний хэл ямар шинжтэй тогтолцоо болсон, хэлний хамт олны дагаж мөрдөх учиртай хэм хэмжээт хэлний тогтолцоотой зэрэгцүүлж үзвэл ямар ялгаа гарах, хэм хэмжээнээс гажсан хэрэглээ хэлний тогтолцооны аль талд хамаарах, ийм алдаа гарах болсон шалтгаан юунд оршихыг нейро хэл шинжлэл талаас тодруулах нь зүйтэй. Тэр тусмаа хэрэв энэ мэт хэрэглээний алдаа тогтвортой зүй тогтол харуулж байгаа бол хувь хүн, эсвэл ажил, мэргэжил нэг хамт олны хэл яаж өөрчлөгдөж байгаа, яагаад өөрчлөгдөж байгааг анхаарч, судалж, шалтгааныг тодруулснаар цаашид гарах алдаанаас сэргийлэх арга зам нээгдэх боломжтой.

2. Судалгааны арга зүй

Өгүүлэлд дүн шинжилгээ хийх баримт болгож 2017-2023 оны хооронд сэтгүүлийн редакцад ирүүлсэн эрдэм шинжилгээний 70 орчим өгүүллээс алдаатай хэрэглээний жишээг түүв. Хэлний салбарын мэргэжилтнүүд хэлний хамт олны бусад хэсгийг бодоход хэлний боловсрол сайн, утга зохиолын хэл илүү сайн эзэмшсэн, хэлний зүй тогтлыг мэддэг, хэлний хэрэглээнд хэм хэмжээг хатуу дагаж мөрддөг байх учиртай. Гагцхүү жишиг, бусдад үлгэр жишээ болох учиртай хэл шинжээчдийн хэл, найруулга хүссэн хэмжээнд байна уу гэвэл баримт эсрэг зүйл өгүүлж байна.

Энэхүү өгүүлэлд удиртгалд өгүүлсэнчлэн судлаачдын “хэлний тухай” (эндээс хэл шинжлэлийн мэдлэг харагдах учиртай) бичсэн хэл тайлбарлах мета хэлийг (эндээс хэлний үзэгдэл тайлбарлаж буй монгол хэл эзэмшсэн түвшин, сэтгэх хэв маяг харагдана) судлахыг оролдов.

Үүний тулд хэлээр дамжуулж мэдээлэл хүлээж авах, таних, боловсруулах, хадгалах, хэрэглэх замаар “өөрийн тархины хэлний тогтолцоо”-г бүтээсэн

судлаачдын бичгийн хэлний хэрэглээнд гарч буй алдааны зүй тогтлыг илрүүлж, ангилан, уг ангилалд тулгуурлан “хэлний хэм хэмжээ буюу хэлний тэмдгийн тогтолцооны хэм хэмжээ” гэх хандлагыг хэл хэрэглэгч, бичвэр бүтээгч хүнд нь суурилж өргөтгөхийг оролдов.


3. Хэм хэмжээ, түүний ангилал

а) Хэлний хэм хэмжээ буюу хэлний тэмдгийн тогтолцооны хэм хэмжээ тэмдгээр илрэхээс гадна ярианы хэлнээ авиагаар илрэх учир дан ганц тэмдэгт хэлний хэлний хэм хэмжээтэй дүйхгүй гэх хандлага хэм хэмжээний онолд давамгайлах уламжлалт хандлага юм. Бүтэц хэл шинжлэл хэлний хэм хэмжээг зөвхөн хэлний тогтолцоотой холбон, түүний түвшний хэрэглүүр, тэдгээрийг хэрэглэх зүй тогтлыг анхаарч, хэлний тэмдэг-нэгжийн хэлбэр, бүтэц, тэмдэг холбох зүй тогтол, дүрэм болон хэрэглээний хүрээнд дуудах хэм хэмжээ, үгийн сангийн хэм хэмжээ, хэл зүйн (үг бүтээх, бүтээвэр зүй, өгүүлбэр зүй) хэм хэмжээг зөрчвөл алдаа байна гэж үздэг. Хэлбэрийн хандлага гэж тодорхойлж болно.

б) Хэм хэмжээг хэл хэрэглэгч, бүтээгч (бидний тохиолдолд бичвэр бүтээгч) хүнд нь суурилж судлах нь.

Танихуйн нейросайнсын нэгэн хэсэг болсон хэлний тухай шинжлэх ухаан (The Cognitive Neuroscience of Language) хүний танин мэдэх үйл болон хэлний холбоо хамаарлыг тархины үйл ажиллагаатай холбон судалж, хүний тархины хөгжил, зохион байгуулалт, хэл ойлгох, боловсруулахад оролцдог мэдрэлийн тогтолцоог тодорхойлохыг эрмэлздэг.

Хэл шинжлэлийн салбарын хос (олон) хэлтэй судлаачийн хэлний хэрэглээг дээр хэлсэн “хүн мэдээлэл боловсруулах замаар өөрийгөө бүтээдэг” гэх орчин цагийн хүн төвтэй хандлагаар судалж, энэ хүн ямар хүн байгааг түүний хэлний хэрэглээгээр харж болно. Хэдэн жил хамарсан хэрэглээний олон баримтаас судлаачийн өнөө үеийн дундаж дүрийг харах боломжтой. Хэлний тэмдгийн тогтолцоо (хоёроос дээш хэлний тогтолцооны хэм хэмжээ) ашиглан бичвэр бүтээдэг (мета хэл, хэлэхүйн хэм хэмжээ), танин мэдэх үйл хийдэг (оршихуйн хэм хэмжээ, хэл шинжлэлийн болон бусад салбарын мэдлэг), сэтгэдэг (логик сэтгэлгээ, сэтгэхүйн хууль), бүтээсэн мэдлэгээ илэрхийлэх санааг хэлний тэмдгийн тогтолцоо ашиглан бичвэрт буулгадаг (хэлэхүйн үйл, найруулан бичих чадвар) гэж задалж, хэлний хэрэглээний хэм хэмжээг зурагт үзүүлсэн байдлаар буулгаж болох юм.



Зураг 1. Хэлний хэм хэмжээний ангилал

Хэлний хэрэглээнд гарч буй алдааг ангилахын тулд энд ангилан харуулсан хэм хэмжээг шалгуур болголоо.

Цэвэр хэлний хэм хэмжээ. Хэл ярианы зөв, оновчтой, ойлгомжтой, яруу, учир шалтгаан, цаг хугацааны холбоо зөв, цаг үе, газар орчиндоо таарсан хэрэглээний хувилбарыг сонгох мэдлэг, чадвар, дадал хувь хэрэглэгч бүрд суусан байхын тулд хэлний түвшин бүрд байх хэм хэмжээг эрдэмтэд нь тодорхойлж, хэлний хамт олон дагах учиртай (Нансалмаа, 2019: 74). Монгол хэлний тухай хуулийн 4-р зүйлийн 1.2. “монгол хэлний хэм хэмжээ” гэж орчин цагийн утга зохиолын монгол хэлний найруулан бичих, зөв дуудах ёс, зүй тогтол, зөв бичих дүрмийг ойлгоно (<https://legalinfo.mn/mn/detail/10932>) хэмээн тайлбар хийж баталсан. Хэлний мэдлэгт хэл зүй эзэмших, үгийн сан эзэмших, зөв хэрэглээ эзэмших үйл багтана (Делл Хаймс) гэж үзэж, хэлний тэмдгийн тогтолцооны хэм хэмжээ болон энэхүү тогтолцоог хэрэглэх хэм хэмжээ гэж ангилав.

Хэлний хэм хэмжээ (хэлний тэмдгийн тогтолцоо, түүний бүтэц, загварт хамаарна, түвшний загвар). Хэлний хамт олны харилцааны явцад шигшигдэж, бэхэжсэн хэлний тогтолцооны уламжлалт, тогтвортой хэрэглээний цогцыг хэм хэмжээ гэнэ. Энэхүү хэм хэмжээ тухайн цаг үед хэлний хамт олон хүлээн зөвшөөрч, нийтээр даган мөрдөж буй жишиг хувилбар болно.

Хэлэхүйн буюу хэрэглээний (энд бичвэрийн) хэм хэмжээ. Найруулгын аль нэг төрөл зүйлд хамаарах бичвэр болон өгүүлэмж бүтээх стандарт шалгуур буюу найруулах хэм хэмжээ эзэмшсэн байдал, өнөө үед хэлний хамт олон хүлээн зөвшөөрч, нийтээр даган мөрдөж буй журамласан жишиг хувилбар эзэмшсэн байдал.

Хэлний бус хэм хэмжээ. Бичвэрээр илэрч гарах хувь хүний хэл шинжлэлийн салбарын болон оршихуйн зүй тогтлын мэдлэг, сэтгэх онцлог, хэлний болон бусад

тэмдэг ашиглах байдал, эрдэм шинжилгээний ёс зүй эзэмшсэн байдал, хандлагыг хамааруулж, дараах гурван зүйлд хуваав. Үүнд:

Үсэг тэмдэг хэрэглэх хэм хэмжээ. Үсэг болон бусад тэмдэг ашиглах дүрэм мэдэхгүйгээс гардаг энэ төрлийн алдаа хэлний тогтолцоог эвддэггүй тул хэлний бус алдаа болно.

Логикийн хэм хэмжээ. Хэлэхүйд буюу бичвэр, өгүүлэмж бүтээхэд дагах учиртай формал логикийн үндсэн хуульд захирагдах: адилсахын хууль, зөрчилгүйн хууль, гурав дахийг үгүйсгэх хууль, хангалттай үндэслэлийн хууль болон судлаач сэдвийн агуулгад хамаарах өөрийн санааг сэтгэхүйн ухагдахуун, бодомж, оюун дүгнэлт хэлбэрээр илэрхийлэх байдал.


Оршихуйн хэм хэмжээ. (Нийгэм, түүх, соёл, шинжлэх ухааны г.м амьдралын бүхий л салбар), түүний бүтэц, хэлбэр, хууль, ертөнцийг үзэх үзэл, хэлэнд туссан ертөнцийн зураглалын тухай хүн төрөлхтөн, аль нэг үндэстэн, хувь хүний төсөөлөл гэж ойлгоно. Танин мэдэх үйлийн үр дүн мэдлэг гэж болно. Юм, үзэгдэл, ухагдахууны холбоо хамаарал, дараалал, ангиллыг буруу илэрхийлбэл алдаа гэж үзнэ.

4. Алдаа, алдааны ангилал, дүн шинжилгээ

4.1. Хэлний алдаа

Бүтэц хэл шинжлэлд хамаарах, хэлний тэмдгийн тогтолцооны түвшин, тэдгээрийн нэгжийн хэлбэр ба утгад хамаарах хэл зүй: бүтээвэр зүй, өгүүлбэр зүй; цэг тэмдэг, том үсгийн дүрэм зөрчсөн; үгийн сан судлал: үгийн утга, нийлэмж үүсгэх зүй тогтол зөрчсөн утга, хэрэглээний алдаа байх ажээ. Хэл шинжлэлийн салбарын мэргэжилтнүүд энэ төрлийн алдаа гаргах нь бага байх учиртай гэж төсөөлж болох ч харамсалтай нь тийм биш байна. Хэлний салбарын мэргэжилтэн өөрийн хэлний тэмдгийн тогтолцоо, хэлний нэгж тэмдэг холбох дүрэм, нэгжийн хэрэглээний хэм хэмжээг бүрэн эзэмшээгүй байгааг ноцтой гэж үзэх, онцгойлон анхаарах хэрэгтэй байна.

Эдгээр шалгуурыг үндэс болгож бичвэрийн алдааны баримтыг анхаарвал хэл зүйн алдаа болон үгийн сангийн алдаа гэж хоёр бүлэг болно.



Зураг 2. Хэлний хэм хэмжээний алдааны ангилал

4.1.1. Хэл зүйн алдаа

Хэл зүйн алдааг хэл зүйн үндсэн гурван салбараар 1. үг бүтээх алдаа; 2. бүтээвэр зүйн алдаа; 3. өгүүлбэр зүйн алдаа гэж ангилав

4.1.2. Үг бүтээх алдаа

Бичигч хэлэхүйн явцад санаандгүй, эсвэл санаатайгаар хэлний үг бүтээх хэмжээ, зүй тогтлыг зөрчиж журамласан, уламжлалт хэрэглээнд байхгүй үг бүтээх ажээ. Нарийвчилж үзвэл 1. бүтээвэр буруу хэрэглэх; 2. үг бүтээх аль нэг загвар ашиглан үг зохиох; 3. хэл зүйн буруу хэлбэр бүтээх; 4. мэдэхгүй үгийг дотоод хэлбэртэй болгохыг оролдох гэж энэ төрлийн алдааг ангилж болохоор байна.

Бүтээвэр буруу хэрэглэж үг бүтээх: Шотландын гаэлик хэл (Scottish Gaelic, гэльский язык) – шотланд хэл. Энд харь хэлний бүтээврийг шууд авч хэрэглэсэн нь алдаа болжээ. Энэ мэтээр орос, англи хэлээр бичсэн бүтээлээс эш татах, орчуулахад бүтээврийг үгийн үндэс мэт ойлгож монгол хэлэнд буулгасан алдаа олон байна.

Монгол хэлний тайлбар толь бичигт “үйл хэргийн хэмжээ, үйл байдал бага бус, санаснаас арай илүү овоо болох нь” хэмээх тайлбартай нэлээд гэх үгийг нэлээдгүй гэх хэлбэрээр хэрэглэх нь их байна. Жишээлбэл, *хэлний өвөрмөц хэлцийн онцлог шинжүүдийн талаарх асуудлуудыг шийдвэрлэхэд бид нэлээдгүй саадтай учирч байна.* Уг өгүүлбэрт тусгайлан заасан алдаанаас гадна найруулгыг нягталж санаагаа оновчтой болгох шаардлага байгаа нь ч харагдана.

Монгол хэлний үйлээс нэр үг бүтээх *-лт* дагаврын хэрэглээ нэн идэвхтэй болсон, хязгаарлалтыг дүрэмд тусгах хэрэгтэй болжээ. Жишээлбэл: *Бэлэн байдал нь суралцахуй талаасаа суралцагчийн боловсорсон байдал, авхаалж самбаа, хүлээлт, багш болон суралцагчийн тохиромж, нийцэмж, хурдан шуурхай байдал, бэлтгэлжилт юм.*

Заахын тийн ялгалын *-ыг /-ийг /-г /Ø/* хувилбараас тэг хэлбэр */Ø/* бараг хэрэглээнээс гарч байх шиг. Мөн нэр үгийн олон тооны хэлбэр англи хэлний дүрмээр үүсгэх нь хавтгайрсан алдаа болжээ. Шалтгаан нь утга, хэрэглээний ялгаа мэдэхгүйд байна. Энэ хоёр тохиолдолд утга, хэрэглээг тайлбарлан, дүрэмд тусгах шаардлагатай.

Бичгийн найруулгад үйл үг бие дааж утга илэрхийлэх чадваргүй мэт төсөөлөх болсон гэмээр хэт сунжирсан нийлмэл бүтэц үүсгэх болсон, эдгээрийн дунд *үйл үг + өгөх* гэх бүтэцтэй загвар бүтээж, хэрэглэх нь илт нэмэгдсэн байна.

4.1.3. Бүтээвэр зүйн алдаа

Үйлийн идэвхгүй хэлбэр (*-гд*) байнга хэрэглэх болсноор (гадаад хэлний бичгийн найруулгын нөлөө) идэвхгүй хэв хэрэглээнд идэвхтэй болсон. Энэ хэрэглээг танихуйн хэл шинжлэлийн үүднээс “монгол хүн идэвхгүй” болсон гэж ч дүгнэж болохоор байна. Жишээлбэл: *Гэсэн хэрнээ охид, хөвгүүдийн тэгш бус*

байр суурийг (үг дутсан, санаа бүрэн илрээгүй) тусгавал охидын ээжүүд сөргөөр үнэлэгдэнэ. (ээжийг сөргөөр үнэлнэ); Туршилтаар өгөгдсөн өвөрмөц хэлцүүд 46% дээш хүртэгдэж, эх хувилбартай утга дүйх хувилбаруудыг өгсөн байна.

Жинхэнэ нэр **хэн, юу** гэх асуултад дангаар хариулахгүй, **хэн нь, юу нь** гэж хариулах болсон. “**нь**” бие даасан үгийн хэмжээнд хэрэглэх болсон, монгол хэлний үгийн давтамж судалж байгаа докторант “**нь**” гэх үг хамгийн их давтамжтай гэж дүгнэсэн байна. Жишээлбэл, *эр хүйсээр зохицох сонголт нь зохицлыг тодорхойлдог зүйл нь нэр үгсийн утгын биеэ даасан байдал хамаарах учраас “өгүүлбэрзүйн төрлийн тодорхой үзэгдэл” (evidently of the syntactic type) гэж Корбетт (Corbett G. , Gender, 1991) баталдаг* гэх мэт.

4.1.4. Өгүүлбэр зүйн алдаа

Өгүүлбэрт 1. үг холбоход дарааллыг нь алдагдуулах; 2. өгүүлбэрийн утгат хэсгийг буруу байрлуулах; 3. өгүүлбэрийн гишүүн хаях; 4. өгүүлбэрийн гишүүнийг төлөөний үгээр буруу орлуулах; 5. өгүүлбэрт шаардлагагүй илүү үг нэмэх, эсвэл дутаах; нийлмэл өгүүлбэрт холбох хэрэглүүрийг буруу хэрэглэх, алгасах, хэт олон хавсарсан өгүүлбэр хэрэглэх, хавсарсан нийлмэл өгүүлбэрт гол өгүүлбэр эзэн биегүй болох, өгүүлэгдэхүүнгүй болох зэрэг алдаа байна.

Эрдэм шинжилгээний өгүүллийг нэг эх (дискурс) хэмээн үзэж гарч байгаа алдааг хянавал 1. эхийн бүтцийн логик дэс дарааг алдуулах; 2. агуулгын нэгдлийг алдуулах; 3. санаагаа дуусгахгүй орхих; 4. өгүүллийн стандарт бүтцийг эвдэх (эхлэл, үндсэн хэсэг, төгсгөл, дүгнэлт) алдаа нийтлэг байна. Нэг өгүүлбэр болон эх олон төрлийн алдаа тайлбарлах эх сурвалж болж байгааг тэмдэглэж зарим жишээ авъя.

а) Гадаад хэлээр бичсэн өгүүлбэрийн бүтэц хуулах:

Салбарын судлаачид судалгааны ажилдаа гадаад хэлээр бичсэн бүтээл ашиглаж буй нь эрдэм шинжилгээний хэл найруулгад олон талаар нөлөөлж байгаагийн нэг нь өгүүлбэрийн бүтэц болжээ.

Жишээ нь: *Финн-угро хэлний бүлгийн мажар болон фин хэлнүүд тун төстэй. Төстэй байдал нь зөвхөн үгсийн сангаар хязгаарлагдахгүй: хэлзүйн хувьд ижил төстэй шинж **чанарууд** олон байдаг. Үүнд: эгшиг зохицох ёсон, залгамал үгзүй, олон тийн ялгалт тогтолцоо, хэлзүйн хүйсгүй зэрэг болно.*

Энэ өгүүлбэрт ижил төстэй шинжүүдийг тийм, тийм шинж гэж өгүүлбэр дотроо оруулалгүй, тусад нь ангид бичиж байгаа нь гадаад хэлний бүтцийг давтсан хэрэг юм. Тодотгож байгаа үг тодотгуулж байгаа үгийн өмнө байна гэх дүрмийг зөрчсөн жишээ мөн гэж болох юм.

Засах хувилбар: *Төстэй шинж зөвхөн үгийн сангаар хязгаарлагдахгүй, эгшиг зохицох ёсон, залгамал үг зүй, олон тийн ялгалт тогтолцоо, хэл зүйн хүйсийн айгүй зэрэг хэл зүйн ижил төстэй шинж олон.*

Жишээ нь: *Зөвхөн 3-р биеийн төлөөний үг хүйс ялгана, гэвч ганц болон олон тоонд.*

Засах хувилбар: *Зөвхөн 3-р биеийн төлөөний үг ганц болон олон тоонд хүйс ялгана.*

в) Өгүүлбэрт утгат хэсгүүдийг буруу байрлуулж, дараалал буруу болсноос агуулга өөрчлөгдөх:

Эрдэм шинжилгээний өгүүлэл судалгааны үр дүн танилцуулдаг, шинэ мэдээлэл танилцуулж эргэлтэд оруулдаг бичвэрийн төрөл. Тиймээс бичвэрт (дискурс) мэдээлэл дамжуулах дарааллыг мэдэх шаардлагатай. Хуучин, танил мэдээлэл (тема, theme) – шинэ, чухал мэдээлэл (рема, rheme) (дэлгэрэнгүй үзэх. Halliday, 2004: 64). Гол төлөв байрыг нь сольж тавих алдаа байна. Энэ талын жишээ харъя.

Жишээ нь: *Шинжлэх ухааны хэл найруулга үүсэж хөгжихөд М.В. Ломоносов өөрийн шавь нарын хамт онцгой үүргийг гүйцэтгэсэн бөгөөд энэ нь XVIII зууны 2-р хагас, XIX зууны сүүлч үе гэхэд бүрэн бие даасан салбар болж төлөвшин тогтсон байна.*

Өгүүлбэрийг утгат хэсгүүдэд хуваая.

(1) *Шинжлэх ухааны хэл найруулга үүсэж хөгжихөд М.В. Ломоносов өөрийн шавь нарын хамт онцгой *үүргийг (үүрэг) гүйцэтгэсэн.*

(бөгөөд)

(2) *Энэ нь XVIII зууны 2-р хагас, XIX зууны сүүлч үе гэхэд бүрэн бие даасан салбар болж төлөвшин тогтсон байна.*

Нэгдүгээр өгүүлбэрт нэрийн бүлэг “М.В.Ломоносов өөрийн шавь нарын хамт”, үйлийн бүлэг нь **юунд?** (шинжлэх ухааны хэл найруулга үүсэж хөгжихөд) гэх асуултаар үг захирах “онцгой үүрэг гүйцэтгэсэн” байна.

Өгүүлбэрийн загвар: Хэн юунд онцгой үүрэг гүйцэтгэсэн.

Юу, хэзээ, яасан гэх загвараар бүтсэн хоёрдугаар өгүүлбэрт “*бүрэн бие даасан салбар болж төлөвшин тогтсон байна*” гэж буй үйлийн эзэн тодорхойгүй болжээ. Энэ нь гэх төлөөний нэр өмнөх өгүүлбэрийн ямар үгийг төлөөлсөн нь ойлгомжгүй. *Бие даасан салбар болж төлөвшин тогтсон байна* гэснээс үүдэн логикоор *шинжлэх ухааны хэл найруулга* гэж тодорхойлж болохоор байна. Тэгвэл “*Шинжлэх ухааны хэл найруулга XVIII зууны 2-р хагас, XIX зууны сүүлч үе гэхэд бүрэн бие даасан салбар болж төлөвшин тогтсон байна*” гэх бие даасан өгүүлбэр гарч ирнэ.

Үүний дараа “*XVIII зууны 2-р хагас, XIX зууны сүүлч үе гэхэд бүрэн бие даасан салбар болж төлөвшин тогтсон шинжлэх ухааны хэл найруулга үүсэж хөгжихөд М.В.Ломоносов өөрийн шавь нарын хамт онцгой үүрэг гүйцэтгэсэн*” хэмээн найруулж болох юм.

Өгүүлбэрийн эхний хувилбарт Ломоносовын оруулсан хувь нэмрийг онцгойлох гэсэн санаа нь сая бичсэн найруулгаар тодорхой болж байна. Хэлсэн зүйлээс гадна бие даасан хоёр өгүүлбэрийг *бөгөөд* гэж буруу холбон, өгүүлбэрийн гишүүнийг төлөөний үгээр буруу орлуулж, өгүүлбэрт буруу байрлуулжээ.

4.1.5. Үгийн сангийн алдаа

Ертөнцийн юм, үзэгдэл, ухагдахууныг нэрлэсэн, хэлний тогтолцооны онцгой нэгж үгийн утга, хэрэглээг судалдаг хэл шинжлэлийн салбар ухаан үгийн сан судлалд хамаарах алдаанд анхаарал хандуулъя. Үгийг түүний утгаас өөр утгаар хэрэглэх (хам бүтцийн харилцааг зөрчих), нийлэмж үүсгэх хэм хэмжээнээс гажих (цуваа бүтцийн харилцааг зөрчих), утга өргөсгөх, явцууруулах, төсөө нэрээр солих, ижил нэр, эсрэг утгатай нэр, ойролцоо утгатай нэр буруу хэрэглэх, олон утгатай үгийн утгыг тодотгохгүй байх болон бусад төрлийн алдааг үгийн сангийн алдаа гэнэ. Үгийн сангийн алдаанд тогтвортой нийлэмжийн хэрэглээнд гарах алдааг мөн хамааруулна.

Үгийн сангийн алдаа нэгжийн хэрэглээг оновчгүй, утгыг тодорхой бус, логик алдаатай болгоно. Хэлсэн зүйлээс хамаарч алдаа олон төрөл байна.

а) Үгийн алдаа дараах шаардлага зөрчсөн байна.

1. утга ойролцоо нэгжүүдийн цуваанаас үг зөв сонгох;
2. тухайн үгийг хэлэнд байгаа утгаар хэрэглэх;
3. уг үгийг харилцааны нөхцөл үүссэн байдалд хэлэнд хэвшсэн, бүгд хүлээн зөвшөөрсөн нийлэмж үүсгэн хэрэглэх.

б) Гадаад үгийн шаардлагагүй хэрэглээ

с) Өвөрмөц хэллэгийн утга, хэрэглээ

Зөвхөн хэлний хэрэглэгдэхүүн сонгохоор хязгаарлагдахгүй, илэрхийлэх санаа, найруулах чадвар муугаас бичвэрийн мэдээлэл илэрхийлэх чанар муу болно. Үгийн сан ядуугаас үүдэн бичигч / өгүүлэгч санаагаа олон янзаар хэлэх чадвар муу, өгүүлбэрийн найруулга тааруу, цөөн хэдэн давтагдсан үг хэллэг хэрэглэж байгаагаас хэл нь нэг хэвийн, ядуухан байна. Үгийн сангийн хэм хэмжээг

1. Үгийн үгийн сангийн тогтолцоонд эзлэх байр суурь, харилцаа, уг үгийн утгын мэдлэг;
2. Үгийн сангийн бусад нэгжтэй холбогдох зүй тогтол гэх хоёр хүчин зүйлээр тодорхойлно.

Үгийн бүтцийн утгын хоёр төрлийг (хам ба цуваа) анхаарахгүй, нарийвчлан судлаагүй, хэл хэрэглэгчдэд хэм хэмжээг боловсруулж өгөөгүй байна, өгөх шаардлага тулгамджээ. Зарим жишээ: *Уг зарчим нь доорх шаардлагыг хэрэгжүүлснээр хангагдана.* Зүй нь: Зарчим хангах гэж монголоор ярьдаггүй, шаардлага хангах гэж ярина. Засах хувилбар: *Дараах шалгуурыг хангаснаар уг зарчим хэрэгжинэ.*

Дараагийн жишээ: *Шарын шашны лам - эмэгтэй хүн хийдэггүй.* Өгүүлбэрт *хийх* гэх үйл үг байна. Үйл үг өгүүлбэрт хэл зүйн болон утгын хамтрагчаа асуултаар удирдан захиална. Уг үйлийг хийх хэн нэгэн буюу үйл үйлдэгч нэрлэхийн тийн ялгалд байна, үйл ямар юманд тусна. Хэл зүйн хэлбэрээс үзвэл өгүүлбэрт байгаа *шарын шашны лам, эмэгтэй хүн* хоёрын аль нэг нь үйл үйлдэгч болж, нөгөөд үйл тусах учиртай. Хийх гэх үйл үг **хэн?**, **юу хийх?** гэсэн асуултаар хамтрагчаа захиална. Үүнийг дагуу “лам эмэгтэй хүнийг хийх, эсвэл эмэгтэй хүн ламыг хийх” болно. Гэтэл утгын зохицлын хуулиар аль аль нь боломжгүй байна. Тиймээс “ямар нэг үйл эзэмших, ажил эрхлэх” гэх утгатай **болох** (багш болох, лам болох) гэх үйл үг авбал сая зөв болох юм. *Хийх, болох* гэх хоёр үгээс утга хэрэглээ харж сонгох нь үгийн сангийн нэгжүүдийн хам бүтцийн утгад хамаарах, ойролцоо утгатай үгийн цуваанаас тухайн өгүүлбэрт энэ үг л утга, хэрэглээгээр яв цав таарна гэх шалгуураар сонгох явдал юм. *Хийдэггүй* гэх хэл зүйн хэлбэрийг дагуулан *болдоггүй* гэх хэлбэрт оруулбал, *Шарын шашны лам эмэгтэй хүн болдоггүй*, эсвэл *Эмэгтэй хүн шарын шашны лам болдоггүй* гэх хоёр хувилбар гарч ирнэ. Логикоор бодвол *Шарын шашны ёс жаягаар эмэгтэй хүн лам болдоггүй* эсвэл *Эмэгтэй хүн лам болдоггүй* гэж найруулах боломжтой. Энэ өгүүлбэр үгийн сангийн шугаман ба шугаман бус бүтэц эвдсэн жишээ бөгөөд өгүүлбэрт байгаа үгс утгаар бие биеэ дэмжиж байж л утга ойлгомжтой өгүүлбэр бүтээнэ.

Бас нэгэн жишээ: *Нэрийн бүлэг эр хүйс болон эм хүйсийн жинхэнэ нэрийг нэгтгэх үед тухайлсан хэлбэрийг сонгоход хоёр хүйсийн хооронд мөргөлдөөн бий болж болно.* Энэ өгүүлбэрт буй *мөргөлдөөн бий болж болно* үйлийн бүлгийг авч үзье. Нэгдүгээрт, үндэс нь *өөр хоорондоо тэмцэлдэх* гэх утгатай **мөргөлдөөн болох** байна. Болзошгүй үйл гэж тэмдэглэхийг хүссэн нь *бий болж болно* гэх хэлбэрээс (нүсэр, мөн үг давтсан) харагдана. Энэ хэлбэрийг *мөргөлдөөн үүсэж магад* гэх мэт хэлбэрээр сольж найруулах боломжтой. Дараагийн зүйл, *мөргөлдөөн болох, үүсэх* мэт нь хэлний хоёр өөр хүйсийн айд хамаарах хоёр нэр үгийн хооронд гэхээс илүү идэвхтэй үйл үйлдэгч хүнд, эсвэл хүний оролцоотой үйлд хамаарах үйл. Тиймээс тухайн үйл үгийг хэрэглэх хүрээг мэдэх нь бас чухал. Ер нь монгол хэлний хэрэглээнд ийм мэтээр үгийн хэрэглээний хүрээ, хязгаарлалтыг анхаарах хэрэгцээ байгааг нийтийн хэлний хэрэглээ харуулж байгаа билээ.

4.1.6. Үг илүүдэх, үг дутах алдаа

Өнөөгийн хэрэглээнд ихэд хавтгайрч байгаа үг илүүдэх алдаа **болох, нь** хоёр болжээ.

- *Тэгэхээр ардын оюун билгийн үнэт өв болох зүйр цэцэн үг нь тухайн.*
- *Лакофф, Жонсон (1980) нар зүйрлэлийн онолыг анх гаргаж ирсэн.*

Дээрх өгүүлбэрт *танихуйн* гэх үг дутсан тул оршихуйн алдаа гарсан. Зүйрлэл судлал эрт эхэлсэн, нэр заасан хоёр эрдэмтэн танихуйн буюу цогц ойлголтын зүйрлэл судлалын эхийг тавьсан.

Шинжлэх ухааны хэлний амин сүнс нь нэр томьёо байдаг. Судалгааны ажлуудад өөрийн ажилд хамаарах түлхүүр нэр томьёог тодорхойлохгүй ердийн үг мэт хандах нь их байна. Хэлний аль нэг үзэгдлийг нэрлэсэн, агуулга, хандлага ялгаатай хэд хэдэн нэр томьёо байх тул энэ мэтийн алдаа судлаачийн хандлагыг бүрхэгдүүлэх гэмтэй.

Үгийн санд хамааруулж үзэх өөр нэг төрлийн алдаа нь хэлний онолын хөгжлийн тухайн цаг үед таарахгүй нэр томьёо (лат. *anachronismus*, англ. *anachronism*, “буруу цаг үед хандах”) хэрэглэх юм. Юм, үзэгдлийг цаг хугацааны хувьд таарахгүй үгээр нэрлэх, орчин цагийн нэр томьёо, үгийг (эсвэл утгыг) өнгөрсөнд тооцох, эсвэл өнгөрсөн цагийн утгаар өнөө цагийн нэр томьёог ойлгох, тайлбарлахад энэ төрлийн алдаа гарна. Жишээ болгож *зүйрлэл* нэр томьёог бүтцийн утгад, уг нэр томьёог танихуйн хэл шинжлэлд хэрхэн ойлгох учиртайг санахад хангалттай.

4.17. Гадаад хэлний үг, нэр томьёо шаардлагагүй хэрэглэх

Хэл шинжлэлийн судалгааны бүтээлүүдэд ихэд хавтгайрсан нэг төрлийн алдаа бол гадаад хэлний үг, нэр томьёоны шаардлагагүй хэрэглээ байна. Энэ төрлийн алдааг гадаад хэлнээс үг зээлэх үзэгдлээс ялгаж үзэх хэрэгтэй бөгөөд үг зээлэхэд гол төлөв үгийн сангийн түвшинд хэлний тогтолцоонд өөрчлөлт гарах бол гадаад хэлний үг, нэр томьёо шаардлагагүй хэрэглэхэд гол өөрчлөлт хэлний бүтцэд хамаарна.

Хэл шинжлэлд энэ төрлийн үзэгдлийн тухайд хэл солих (Code-switching) нэр томьёо хэрэглэдэг. Хэл солих гэдэг нь нэг өгүүлэгч нэг ярианд (өгүүлбэрт) хоёр (эсвэл илүү) хэлний хэрэглүүр ашиглахыг хэлнэ.

Гадаад үг нэрлэж байгаа юмтайгаа (компьютер, интернэт) орж ирсэн бол хэрэглээг зөвтгөж болох бөгөөд энэ бол үг зээлэх үзэгдэл. Хэрэв монгол хэлэнд утга бүрэн дүйцэх үг, нэр томьёо байгаа бол хэрэглэх шаардлагагүй. Хувь хүн бүрийн сэтгэлгээний хэл олон янз хүчин зүйлийн нөлөөгөөр ялгаатай, хэлний тогтолцоонд орж ирж байгаа үг зээлэх үзэгдэл шиг зүй тогтол нь шууд харагдахгүй тул хэлний хэрэглээнд хамаарах энэ үзэгдлийн шалтгааныг тогтоож багцлах амаргүй ч зарим нэг зүй тогтлыг тодорхойлох боломж байна.

Өгүүлбэрт гадаад үг болон өөрийн хэлний үг, нэр томьёо зэрэгцүүлэн хэрэглэх нь их байна. Сэтгэл зүйн хүчин зүйл талаас бодвол монгол нэр томьёо хэлэх гэсэн санааг нь бүрэн илтгэж чадахгүй гэж үздэг гэлтэй. Жишээлбэл:

- *Дүгнэлт (conclusions)-ийг товч тодорхой гаргах гэсэн мэдээллийн хэл, хэллэгийн зарчимтай байна.*
- *Сэтгэхүй гэдэг нь учир шалтгааныг нэн нарийн уялдаанд тодорхойлогч бөгөөд эргэцүүлэн бодох хийсвэр дарааллыг онцлон гаргаж, анализ синтезийн буюу задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх үйлдлүүдийн нягт харилцан уялдаанд явагддаг.*

- Аливаа хэлний өргөлтийг авиазүйн аль нэг шинж давамгайлж байгаагаас үүдэн хүчлэх (*динамическое ударение, dynamic/stress/accent*), эгшиглэх (*музыкальное/мелодическое ударение, musical accent*), тоон (*количественное/квантитативное ударение, quantitative stress*) гэсэн гурван хэв шинж болгон ангилдаг.

Орчуулан хэрэглээд нэгэнт хэвшсэн үг байхад гадаад үг хэрэглэсэн:

- Жинхэнэ бодит мэдээллийг боловсронгуй болгосон нь текстийн бичлэгийн нотолгоо болон бодит байдалд байдаг зайлиггүй зүйл юм.
- Тэгэхээр хоёр дахь нэршилээр үүссэн нэгжийн хувьд дахин кодлох процессын үед дээрх хоёр системийн оролцож буй түвшинг тогтоох явдал чухал ач холбогдолтой юм.
- Судалгааны үр дүнд харь хэлний дүр байдал илэрхийлсэн өвөрмөц хэлцийг хүртэх явцын прагматик болон когнитив харилцан хамаарлыг тогтоосон.
- Туришилтын материалыг сонгоход хангалттай эх сурвалж материал монгол хэлний хувьд байхгүй байсан.

Гадаад үгийн шаардлагагүй хэрэглээ мэдлэгийн алдаатай хавсарсан байх:

- а) Хэлбэрт алдаа гарсан: мэргэжлийн үг хэллэг гэх утгаар профессионализм гэх хэлбэр гаргаж ирсэн, толь бичгээр шалгаагүй.
- б) Утгын алдаа гарсан: Профессионализм гэж хэлэх гэсэн болов уу гэж таамаглаж, толь бичгээр шалгахад судлаачийн хэлэх гэсэн **мэргэжлийн үг хэллэг** гэснээс ялгаатай “профессионализм – янз бүрийн нөхцөл байдалд мэргэжлийн нарийн ажлыг үр дүнтэй, найдвартай хийж чаддаг хүний шинж” гэсэн тайлбар байна.

Ийм төрлийн жишээ хэлний хүйс, хүйстэй хэл зэрэг болно. Гадаад хэлний нэр томъёог орчуулан хэрэглэхдээ уг үзэгдлийн агуулга талыг нягтлаагүйгээс буюу тодруулбал, хэл хүйстэй байх уу? гэх асуулт тавилгүй, шууд үгчлэн орчуулах арга хэрэглэсэнээр ийм төрлийн алдаа гарчээ.

Гадаад үгийн хэрэглээнд хамааруулах өөр нэг төрлийн алдаа гадаад хүний нэрийн хэрэглээ байна. *John, James* мэт нэрд байгаа *J -г Дж, Ж* гэж хувилбартай хэрэглэж буй нь хамгийн их байна (*Джон Локк (John Locke), Уильям Жемс (James W.), Дж Ст. Милль (John Stuart Mill)*).

Мөн судлаачид их эш татдаг *L. Wittgenstein* нэрээс *Л. Виттгенштейн, Л. Витгенштейн, Jean Piaget* нэрээс *Пиаже, Пиажет* гэх хувилбартай хэлбэр үүсгэн хэрэглэж байна. Хувилбартай хэвшвэл судлаачаа танихгүй болох гэмтэй тул энэ мэтээр судалгааны бүтээлд зайлшгүй гардаг гадаад хүний нэр журамлах цаг болжээ. *Эрнест Мах (Max E.)* мэтийн хэрэглээ мэр сэр байх ч хувь хүнд хамаарах, хэлний тогтолцоо эвдэхгүй, хоёр хэлний тэмдэг хольсон, энд бичсэнээр 4.1.3-т хамаарах “Үсэг тэмдгийн алдаа” болно.

4.1.8. Хэл тайлбарлах хэлний хэрэглээний алдаа

Хэлний тэмдгийн тогтолцооны шинжтэй алдааг ийн авч үзсэний дараа хэл тайлбарлах хэлний хэрэглээний алдаа (мета хэлний) буюу найруулгын алдааг онцгойлон анхаарах хэрэгтэй болсныг тэмдэглэе. Хэлний аль нэг түвшинд хамаарах алдааг тэдгээрийн хэрэглээ буюу найруулах чадвартай холбох нь зүйтэй. Зарим судлаач энэ тухайд бүтээвэр зүйн найруулга, үгийн сангийн найруулга, өгүүлбэрийн найруулга мэт нэр томьёо хэрэглэж, хамтад нь авч үздэгтэй санал нэг буйгаа хэлье.

Үйлдсэн бичвэр нь бичигчийн өмнөө тавьсан зорилгод хүрээгүй буюу уншигчид ойлгомжгүй, санаагаа товч, оновчтой илэрхийлж чадаагүй, үгийн баялаг хомс, хэл хольсон, заримдаа юу хэлэх гэсэн нь бүр ойлгомжгүй, бичвэрийн бүтэц алдагдуулсан, эрдэм шинжилгээний бүтээл бичих чадвар дутсан, нийлмэл өгүүлбэр бичихдээ орооцолдож санаагаа гаргаж чадаагүй алдаа олон болжээ.

4.2. Хэлний бус алдаа

Хэлний бус алдааг

1. Үсэг тэмдгийн алдаа
2. Логикийн хэм хэмжээ зөрчсөн алдаа
3. Оршихуйн хэм хэмжээ зөрчсөн алдаа гэж гурав ангилав.

4.2.1. Үсэг тэмдгийн алдаа

Үсэг, тэмдгийн алдаа хэлний тогтолцооны аль нэг түвшинд хамаарахгүй, бичвэрт үсэг болон бусад тэмдэг ашиглахад гардаг зөвхөн хэлбэрт хамаарах алдаа бөгөөд хэлний тогтолцоог эвддэггүй тул хэлний бус алдаа болно, яаж, хаана бичих дүрэм мэдэхгүй байх, анхааралгүй, яарч бичих, хянаагүйгээс үүднэ. Хувь хүний хүчин зүйлээс хамаардаг, үсэг, тэмдгийн дүрэм тусгайлан анхаарч сураагүй, даалгавар гүйцэтгэх үед анхаарал муу, төвлөрөөгүй, бичсэн зүйлээ хянаагүй зэрэг шалтгаантай, засахад амархан алдаа байна.

Ийм мэтийн алдаанаас хамгийн их давтамжтай нь салгаж бичихээр журамласан дараах тохиолдол байна. Үүнд:

a) Хэлзүйн хувилбар, судалгааны аргазүй, номзүй, хэлишинжлэл, нэртомьёо

Нэр ,томьёо гэхэд *Ь* тэмдэг бичнэ гэж журамласныг дагаагүйгээс нэртомьёо, нэр томьёо гэх хоёр хувилбар зэрэгцүүлэн хэрэглэж байна.

Англи хэлний нөлөө том үсгийн дүрэмд хамгийн их хамаарч байна:

b) Монгол, Англи, Орос хэлний өргөлт нийтлэг хийгээд ялгагдах өвөрмөц онцлогтой.

- Швед, Япон, Литов зэрэг бусад олон хэлэнд.

- Судалгааны Арга Зүй

Хувь бичигч анхааралтай бичээгүй, бичсэнээ хянаагүйгээс үсэг тэмдгийн алдаа гаргасныг дараах мэдээллийг, ажилгаан, холбогдно, овлиггүй мэт хэрэглээнээс харж болно.

- Шинэ мэдлэг, мэдээллийг олж үзэх (зөв нь мэдээлэл)
- Л.С.Выготскийн суралцахуйн үйл ажиллгаан (зөв нь ажиллагаа) дахь нийгэм, соёлын нөлөө, ойрын хөгжлийн бүсийн онолтой суралцахуйн бэлэн байдал холбогдно (зөв нь холбогдоно).

4.2.2. Логикийн хэм хэмжээ зөрчсөн алдаа

Дараагийн бүлэг алдаа санаа илэрхийлэхэд хамаарах багц алдаа буюу логик алдаа байна. Энэ төрлийн алдааг бүхэлд нь зөв сэтгэх чадварт хамаарна гэж томъёолж ч бас болох юм. Шинжлэх ухааны аль ч салбарт хийсэн судалгааны ажил бүхэлдээ логикт захирагдах учиртай. Ажлын бүтэц, бүтцийн нэгжүүдийн бичвэр дэх дараалал, илэрхийлж буй санааны логик дараалал, учир шалтгааны холбоог зөв гаргахгүй байх ажээ. Ухагдахуун, бодомж, оюун дүгнэлт гэх сэтгэх гурван хэлбэр алдаатай. Ажлын сэдэв, зорилго агуулгатай зөрсөн алдаа түгээмэл байна. Гол чухал санааг чухал бус санаанаас ялгаж чадахгүй байх нь элбэг. Судалгааны үр дүнгээ танилцуулахдаа үндэслэл, баталгаа гэх хоёр чухал хүчин зүйл ашиглах нь ховор. Жишээ 1. Хүйсийн ялгаагүй хэлэнд эрэгтэй хүний ерөнхий хэрэглээ нь нэр үгийн хамт байдаг.

Энэ өгүүлбэрт хэл зүйн хүйсийн айн тухай ярьж буй мэт боловч “эрэгтэй хүнийг хэрэглэх” тухай ярьж, энэ хэрэглээ нэр үгийн хамт байдаг гэх нь сэтгэх үйлийн аль нэг хуульд захирагдах боломжгүй. Ийм мэт өгүүлбэр харьцангуй цөөн боловч байгаа нь харамсалтай.

- Эр хүйсийг илүүд үздэг орос, польш гэх мэт хэлнүүдэд эм хүйсийн нэр томъёог нэр хүндтэй ажил мэргэжилд хэрэглэхээс зайлсхийдэг.

Энэ өгүүлбэр дээрх өгүүлбэрийн нэг адил санаагаа оновчтой илэрхийлээгүй, өгүүлбэрт үг дутсан, үгийн дараалал алдаатай, хэлний хэл зүйн хүйсийн ай болон хүний биологийн хүйсийг нэг юм болгож нэгтгэсэн зэрэг алдаа гарсан нь өгүүлбэр бүхэлдээ ойлгомжгүй, сэтгэлгээний алдаатай болоход хүргэсэн байна.

Жишээ 2. Тэд хэл яриа нь хүний амьдралын чухал хэсэг, хэл, сэтгэлгээ, үйл хөдлөлтэй холбоотой байдаг гэж үзсэн. Энэхүү судалгаагаар хар өнгө бүхий зүйрлэлийн ихэнх нь сөрөг аялгуутай бөгөөд “заналхийлэл”, “хууль бус”, “муу / хорттой”, “стандарт бус”, “өвчтэй / эрүүл бус”, “доромжлол”, “аюултай”, “тааламжгүй”, “далд/нууц” гэх мэт зүйрлэсэн утгатай болохыг олж чадсан.

Жишээ болгож авсан энэ бичвэрт олон төрлийн алдаа холилджээ:

Тэд хэл яриа нь хүний амьдралын чухал хэсэг, хэл, сэтгэлгээ, үйл хөдлөлтэй холбоотой байдаг гэж үзсэн гэх өгүүлбэрт үг илүүдсэнийг зураасаар дарав. Энэхүү судалгаагаар хар өнгө бүхий зүйрлэлийн ихэнх нь сөрөг аялгуутай бөгөөд “заналхийлэл”, “хууль бус”, “муу / хорттой”, “стандарт бус”, “өвчтэй / эрүүл бус”, “доромжлол”, “аюултай”, “тааламжгүй”, “далд / нууц” гэх мэт зүйрлэсэн утгатай болохыг олж чадсан.

Энэхүү гуравдугаар өгүүлбэрт *хар өнгө бүхий зүйрлэл* гэснээс зүйрлэл өнгөтэй, *хар өнгө бүхий зүйрлэлийн ихэнх нь сөрөг аялгуутай* гэснээс аялгуу сөрөг ба зэрэг байж болно гэж ойлгохоор болжээ. Тайлбар дутуу хийсэн нь сэтгэлгээний алдаа илрэхэд хүргэсэн.

4.2.3. Оршихуйн хэм хэмжээ зөрчсөн алдаа

Энэ төрлийн алдаа танин мэдэхүйн буюу тодруулбал, мэдлэгийн алдаа юм. Өөрийнх нь бичихээр сонгосон сэдвийн хүрээний болон хэл гэж юу вэ гэх хэл шинжлэлийн онолын суурь мэдлэг дутсан байх тул алдаатай үндэслэл гаргах, алдаатай тайлбар, ангилал хийх, хэл шинжлэлд нэгэнт шийдсэн асуудлыг судлаагүй, шийдээгүй, өөрөө л энд анх судалж буй мэт хандах зэрэг нь их байна. Ерөөс аль нэг сэдэв сонгосон бол уг сэдвийн хүрээнд өөрөөс нь өмнө гарсан бүтээлийг барж уншиж, тэр хүрээнд ажиллаж судалгааны бүрэн тойм хийхгүй бол энэ төрлийн алдаа гарсаар байна.

Судалгааны ажлуудад өөрийн ажилд хамаарах түлхүүр нэр томьёог тодорхойлохгүй ердийн үг мэт хандах нь их байна. Хэлний аль нэг үзэгдлийг нэрлэсэн, агуулга, хандлага ялгаатай хэд хэдэн нэр томьёо байх тул энэ мэтийн алдаа судлаачийн хандлагыг бүрхэгдүүлэх гэмтэй.

Мэдлэгийн хоёр өөр салбарт хамаарах үзэгдлийг холих (жишээ нь, хэл шинжлэлийн утга хэмээх нэр томьёог логикийн санаа гэх нэр томьёогоор солих), эсвэл шинжлэх ухааны нэг салбарын өөр өөр цаг үед хамаарах өөр өөр хандлагыг нэг мэт ойлгох (жишээ нь танихуйн хэл шинжлэл талаас судалгаа хийх тохиолдолд зүйрлэл гэх нэр томьёо “хүний сэтгэх арга” гэх ухагдахуун илэрхийлэх тул адилтгал, зүйрлэл гэх нэр томьёо ашиглах, эдгээр нэр томьёог барьж ангилах шаардлагагүй. Адилтгал, зүйрлэл гэх нэр томьёо бүтцийн утгад хамаардаг тул (хэл шинжлэлийн хөгжлийн хоёр өөр шатанд зүйрлэл гэх нэр томьёоны агуулга өөрчлөгдсөн тул алдаа гарахад хүргэдэг) мэт алдаа түгээмэл байна. Жишээлбэл:

- *Өгүүлэмжийн тодорхойлж байгаа зүйлийн утгазүйн цэгцтэй дараалал*
- *(утга судалдаг салбар ухааны нэр утга зүйг өгүүлбэрийн утгатай адил мэт үзсэн; өгүүлбэрийн утга, хэл шинжлэлийн утга зүй гэх нь зөв)*
- *Нийгмийн шинжлэх ухааны хэл, хэллэгт (найруулгад гэвэл зохилтой) хэрэглэсэн **өгүүлбэр зүйг** (өгүүлбэр баймаар) хими, физик, технологийн хэллэгт ашиглахгүй нь ойлгомжтой.*
- *Зөрүүд, тэнэг зан авиртай хүнийг мал (23), үхэр (14), сарлаг (9), илжиг (7), буруу ишилсэн сүх (7), дөргүй сарлаг (5), дөргүй бух (2) гэх зэргээр таван хошуу малын ерөнхий нэрээр нэрлэх (илжиг, буруу ишилсэн сүх таван хошуу малд хамаарах уу?)*
- *Хэлний хүйсийн асуудлыг судлаачид нэлээд судалжээ. Уг өгүүлбэрт хэлний хүйсийн айн асуудал гэхийг хэлний хүйсийн асуудал болгосноор мэдлэгийн алдаа гарсан.*
- *Ихэвчлэн хүйстэй хэлнүүд хоёр юм уу гурван хүйстэй. Энэ жишээ “Хэл*

хүйстэй, хоёр, гурван ч хүйстэй байж болно” гэж баталсан.

- Англи улсын авиа зүй гэснээс авиа зүй бол улсад хамаарах асуудал гэж үзсэн. (Авиа зүй хэлний авиа судалдаг салбар ухаан тул англи хэлний авиа зүй гэх нь зөв).

Өгүүллийн эхэнд хийсэн хэм хэмжээний ангиллын дагуу бичвэрт буй алдааг ангилан, шинжилсний дараа бие даасан бүлэг болгож үзэхээр хэмжээнд байгаа эрдэм шинжилгээний ёс зүй, оюуны өмчийн эрх зүйд хамаарах алдаа их байгааг тэмдэглэе. Энэхүү бүлэг алдаанд өөрийн ба хүний бичсэнийг санаатай, санаагүй ялгаагүй, дам эш татсан, өөрөө бичсэн гэхээс илүү хуулсан гэж үзэхэд хүргэх алдаа багтана. Эдгээрээс гадна ажлын техник гүйцэтгэлд хамааруулах алдаа их байна. Эрдэм шинжилгээний сэтгүүл авч хэвлэх өгүүлэлдээ тодорхой шаардлага тавьдаг, бичгээр өгч танилцуулдаг боловч дагаж мөрдөхгүй байгааг тайлбарлахад хэцүү ч магадгүй хувь хүний сахилга баттай холбох учир байж болох юм.

5. Дүгнэлт

Хэлний хэрэглээ хэм хэмжээнээс гажих үзэгдлийг

- (1) Хэлний тогтолцоо эвдэх (бичигч дүрэм сайн мэдэхгүй): хэлний түвшинд хэл хоорондын нөлөө зүй тогтлын шинжтэй болсон, дүрэм сайн мэдэхгүйгээс нэг хэлний хэрэглээнд нөгөө хэлний дүрэм хэрэглэдэг.
- (2) Хэлний хэм хэмжээ зөрчих (бичигч дүрэм мэднэ, гэвч хязгаарлалт мэдэхгүй): хэлний хамт олонд зориулж боловсруулсан дүрэм хэрэглээний явцад гарч ирэх хэлний нэг үзэгдэлд хамаарах бүх тохиолдлыг тайлбарлаагүйгээс үүднэ: /-ыг/ ийг/ г /Ф /, -лт, олон тооны төгсгөл.
- (3) Хэрэглээний хэм хэмжээ мэдэхгүй (бичигч хэрэглээний ямар нөхцөл байдалд аль хувилбар хэрэглэхээ мэдэхгүй) байна гэж нэгтгэж болно.

Алдааг сая авч үзсэн байдлаар ангилж, тайлбар хийсний дараа алдаа гарах шалтгаанаар нь нэгтгэн үзвэл, дараах дүр зураг харагдаж байна. Үүнд:

1. Монгол хэлний бүтэц, үүргийн мэдлэг, найруулах дадал, ур чадвар хангалтгүй байна.
2. Хэл шинжлэлийн онолын мэдлэг хангалтгүй, хэл шинжлэлийн судалгааны арга зүйд суралцаагүй байна.
3. Харь хэл монгол хэлэнд нөлөөлөх үзэгдэл буюу интерференцийн үзэгдэл илт болжээ.

Алдаа гарах үндсэн шалтгааны нэг нь хэл хоорондын харилцаа, бидний тохиолдолд судлаачид хэрэглэж буй англи, орос хэлээр бичиж туурвисан бичгийн хэлний нөлөө хэмээн дүгнэж болохоор байна. Хэлсэн зүйл судалгааны өгүүлэлд туссан харь хэлний өгүүлбэрийн бүтэц, үг бүтээх загвар, гадаад үг, нэр томьёо, найруулах хэв маяг зэргээс харагдана. Залуу судлаачид хос (зарим тохиолдолд гурав) хэлээр шинжлэх ухааны мэдлэг хүртэж, бичгийн хэлэнд гадаад хэлний хэрэглээ, хэрэгцээ давамгайлж байгаа, хоёр хэлний хэрэглээг бүрэн хянах чадвар суугаагүй, туршлага бага байгаагаас хэл холилдох үзэгдэл илт болж, улмаар эрдэм шинжилгээний бичвэрт зүй тогтол болон илрэх болжээ.

Ном зүй

Монгол хэлээр

Монгол хэлний тухай хууль [*Mongol helnii tukhai khuuli* [Law on Mongolian Language]. <http://www.legalinfo.mn/law/details/10932>

Нансалмаа, Н. (2019). *Нийгэм хэл шинжлэл*. Улаанбаатар: МУИС Пресс. [Nansalmaa, N. *Niigem khel shinjlel* [Sociolinguistics]. Ulaanbaatar: NUM Press. 2019.]

Орос хэлээр

Ахутина, Т.В. (1989). *Порождение речи. Нейролингвистический анализ синтаксиса*. Москва: Издательство Москва университета. [Akhutina, T.V. *Speech Production: Neurolinguistic Analysis of Syntax*]. Moscow: Publishing House of Moscow University. 1989.]

Баранникова, Л.И. (1972). *Сущность интерференции и специфика ее проявления // Проблемы двуязычия и многоязычия*. Москва: Наука. [Barannikova L.I. *The Essence of interference and its specific manifestations. // Problems of bilingualism and multilingualism*]. Moscow: Science. 1972.]

Вайнрайх, У. (1972). *Одноязычие и многоязычие. новое в лингвистике*. Москва: Прогресс. [Weinreich, U. *Monolingualism and multilingualism. New in linguistics*]. Moscow: Progress. 1972.]

Вайнрайх, У. (1979). *Языковые контакты: Состояние и проблемы исследования*. Киев: Издательство при Киев Университета. [Weinreich, U. *Languages in contact*]. Kiev: Publishing House of Kiev University. 1979. https://doi.org/10.1007/978-3-642-52199-7_8

Виноградов, С.И. (2003). *Норма лексическая // Культура русской речи: Энциклопедический словарь-справочник*. Флинта. [Vinogradov. S.I. *Lexical norm // Culture of Russian speech: Encyclopedic dictionary-reference book*]. Flinta. 2003.]

Виноградов, В.А. (1983). *Стратификация нормы, интерференция и обучение языку // лингвистические основы преподавания языка*. Москва: Наука. [Vinogradov. S.I. *Norm stratification, interference and language teaching // Linguistic foundations of language teaching*]. Moscow: Science. 1983.]

Виноградов, В.А. (1990). *Интерференция // Лингвистический энциклопедический словарь*. Москва: Сов. Энциклопедия. [Vinogradov. S.I. *Interference//Linguistic Encyclopedic Dictionary*]. Moscow. 1990.]

Жлуктенко, Ю.А. (1974). *Лингвистические аспекты двуязычия*. Киев: Издательство при Киев Университета. [Zhluktenko, Yu.A. *Linguistic Aspects of Bilingualism*]. Kiev: Publishing House of Kiev University. 1974.]

Залевская, А.А. (2013). *Введение в психолингвистику*. Москва: Direct Media. [Zalevskaya, A.A. *Introduction to Psycholinguistics*]. Moscow: Direct Media. 2013.]


Залевская, А.А. (2008). *Психолингвистический подход к проблеме ошибки*. Екатеринбург: Урал гуманитар. ин-т. [Zalevskaya, A.A. *Psycholinguistic approach to the problem of error*. Yekaterinburg: Ural. gumanitar. in-t. 2008.]

Полинская, М.С. (1987). *Полуязычие / Возникновение и функционирование контактных*

- языков. Москва. [Polinskaya, M.S. Semilingualism // The emergence and functioning of contact languages. Moscow. 1987.]
- Рогозная, Н.Н.** (2003). *Типологи лингвистической интерференции в русской речи иностранцев (на материале разноструктурных языков)*. Москва. [Rogoznaya, N.N. *Typology of Linguistic Interference in the Russian Speech of Foreigners (Based on the Material of Differently Structured Languages)*. Moscow. 2003.]
- Теньер, Л.** (1988). *Основы структурного синтаксиса (Языковеды мира)*. Москва: Прогресс. [Tenier, L. *Fundamentals of Structural Syntax (English translation: Elements of Structural Syntax)*]. Moscow: Progress. 1988.]
- Хауген, Э.** (1972). *Процесс заимствования // новое в лингвистике*. Москва: Прогресс. [Haugen, E. *The analysis of Linguistic Borrowing*]. Moscow: Progress. 1972.]
- Розенцвейг, В.Ю.** (1972). *Языковые контакты. Лингвистическая проблематика*. Ленинград: Наука. [Rosenzweig, V.Yu. *Language Contact. Linguistic Issues Leningrad: Science*. 1972.]
- Росетти, А.** (1972). *Смешанный язык и смешение языков // Новое в лингвистике*. Москва. [Rosetti, A. *Mixed language and Confusion of Languages // New in linguistics*]. Moscow. 1972.]
- Цейтлин, С.Н.** (1982). *Речевые ошибки и их предупреждение*. Москва. [Tseytlin, S.N. *Speech Errors and Their Prevention*]. Moscow. 1982.]
- Фоменко, Ю.В.** (1994). *Типы речевых ошибок*. Новосибирск: Издательство НГПУ. [Fomenko, Yu.V. *Types of Speech Errors*]. Novosibirsk: Publishing house of Novosibirsk State Pedagogical University. 1994.]

Англи хэлээр

- Aitchison, J.** (2003). *Words in the Mind: An Introduction to the Mental Lexicon (3rd ed.)*. Oxford, UK: Black-well.
- Ferguson, C.A.** (1959). *Diglossia // Word. vol.15. (2): 325-340*.
- Halliday, M.A.K.** (2004). *An Introduction to Functional Grammar (3rd ed.)*. London: Edward Arnold.
- Thomason, S. G.** (2001). *Language Contact*. Edinburgh University Press.
- Wilkins, D.P6** (1996). *Morphology // H.Goebel et al. (eds.) Contact Linguistics*. Berlin: New York (V.1): 109-117.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.